

**МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС ЭРХ БҮХИЙ ХУУЛЬ САХИУЛАХ БОЛОН
ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГАД
МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү журмыг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаас мөнгө угаах, түүний суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг шалгахад хамаарах Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээд (цаашид “мэдээлэх үүрэгтэй этгээд” гэх)-д мөн хуулийн 7 дугаар зүйлд заасан тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын мэдээллийг (цаашид хамтад нь “мэдээлэл” гэх) авах хүсэлт гаргах, мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээллийг өгөх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөнө.

1.2.Энэ журамд заасан “эрх бүхий хууль сахиулах байгууллага” гэдэгт цагдаа, тагнуул, авлигатай тэмцэх байгууллагыг, “терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага” гэдэгт тагнуулын байгууллагыг тус тус ойлгоно.

1.3.Мэдээлэх үүрэгтэй этгээдээс терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад мэдээлэл өгөх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг Засгийн газрын 2019 оны 464 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам”-аар зохицуулна.

ХОЁР. МЭДЭЭЛЭЛ

2.1.Эрх бүхий хууль сахиулах байгууллага Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.1-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээдээс авах мэдээлэлд доор дурдсаныг ойлгоно:

2.1.1.тодорхой этгээд нь тухайн банканд аливаа данс /харилцах, хадгаламж, зээл гэх мэт/ эзэмшдэг, эсхүл данс эзэмшиж байсан эсэх;

2.1.2.нэг эсхүл хэд хэдэн дансны хамтран эзэмшигч, дэд эзэмшигч болон итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн эсэх;

2.1.3.хэрэв банканд данстай бол тухайн дансны үлдэгдэл;

2.1.4.хадгаламжийн хайрцаг /үнэт зүйл хадгалах хайрцаг/ эзэмшдэг, эсхүл эзэмшиж байсан эсэх;

2.1.5.данс нээгдсэн өдрөөс хойших эсхүл тодорхой заасан хугацааны гүйлгээний хуулга (“Банкнаас дансны хуулга авах маягт”-ын дагуу);

2.1.6.оролцогч талуудын тухай мэдээлэл;

2.1.7.СВИФТ гүйлгээний хуулга.

2.2.Энэ журмын 2.1.5-д заасан дансны хуулга нь гүйлгээний огноо, гүйлгээ хийсэн цаг, гүйлгээ хийсэн салбарын код, теллер дугаар, данс эзэмшигч, харьцсан банк, харьцсан

данс, регистрийн дугаар, гүйлгээний код, валютын төрөл, гүйлгээний утга, орлого, зарлага, үлдэгдлийн талаарх мэдээлэл зэрэг мэдээллийг агуулна.

2.3.Эрх бүхий хууль сахиулах байгууллага Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.1-д зааснаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдээс “Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдээс гүйлгээний тухай мэдээлэл авах загвар”-ын дагуу мэдээллийг авах бөгөөд загвар нь дараах мэдээллийг агуулсан байна:

2.3.1.тодорхой этгээд нь тухайн мэдээлэх үүрэгтэй этгээдээр үйлчлүүлж байсан эсэх;

2.3.2.тодорхой этгээд нь тухайн мэдээлэх үүрэгтэй этгээдийн харилцагч эсхүл харилцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч эсэх;

2.3.3.мэдээлэх үүрэгтэй этгээдээс үзүүлсэн үйлчилгээний төрөл, хугацаа, холбогдох мэдээлэл;

2.3.4.хэрэв данстай бол тухайн данстай холбоотой мэдээлэл;

2.3.5.данстай холбоотой бусад данс, оролцогч талуудын тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

2.3.6.тодорхой этгээдийн нэрийн өмнөөс хийсэн гүйлгээ;

2.3.7.шаардлагатай бусад мэдээлэл,

2.4.Мэдээлэл нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно. Мэдээллийг энгийн болон яаралтай горимоор, цахимаар эсхүл биечлэн авч болно.

2.5.Цагдаагийн байгууллагын Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Экологийн цагдаагийн алба, Хар тамхитай тэмцэх газар болон тагнуул, авлигатай тэмцэх байгууллага шаардлагатай тохиолдолд энэ журмын 2.4-т заасан яаралтай горимоор цахим хэлбэрээр мэдээлэл авч болно.

2.6.Эрх бүхий хууль сахиулах байгууллага нь мэдээлэх үүрэгтэй этгээдээс хүсэх мэдээллийн хэмжээ, түүнийг боловсруулах боломжит хугацааг харгалзан, зайлшгүй тохиолдолд мэдээллийг яаралтай горимоор цахимаар авах зарчмыг баримтална.

2.7.Эрх бүхий хууль сахиулах байгууллагаас мөрдөн шалгах ажиллагааг түргэвчлэх зорилгоор мэдээллийг цахим хэлбэрээр авч болно. Шаардлагатай тохиолдолд уг мэдээллийг цаасан хэлбэрээр баталгаажуулна.

ГУРАВ. МЭДЭЭЛЭЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХ

3.1.Эрх бүхий хууль сахиулах байгууллага нь мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлэл авах хүсэлт нь тус байгууллагын билэгдэл, хаяг, огноо, дугаар бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас дээр тухайн байгууллагын эрх бүхий удирдах албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга, тэмдэгтэй байх бөгөөд холбогдох хуульд заасны дагуу прокуророос зөвшөөрөл авсан байна.

3.2.Энэ журмын 3.1-т заасан хүсэлтэд дараах мэдээллийг тусгана:

3.2.1.тодорхой этгээдэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээр арга хэмжээ авах эсэхийг тодорхойлох зорилготойгоор хүсэлт гаргах болсон шаардлага, үндэслэлийг бичих;

3.2.2.хүсэлтийг хаяглаж байгаа мэдээлэх үүрэгтэй этгээд, түүний салбар, нэгжийн нэр, байршил;

3.2.3.тодорхой этгээдийн тухай мэдээлэл /хувь хүн бол овог, нэр, иргэний үнэмлэх, регистрийн дугаар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистрийн дугаар, хаяг гэх мэт/-ийг тодорхой бичих;

3.2.4.хүсэж буй энэ журмын 2.1, 2.3-т заасан мэдээлэл;

3.2.5.энэ журмын 2.4-т заасан мэдээллийн хэлбэр, мэдээллийг хүлээн авах хэлбэр, горим (мэдээллийг цаасан хэлбэрээр авах хүсэлт гаргах бол шуудангийн хаяг, цахим хэлбэрээр авах хүсэлт гаргах бол албаны цахим шуудангийн хаяг, биечлэн авах бол хүлээн авах ажилтны нэр, албан тушаал, утасны дугаарыг бичсэн байх);

3.2.6.зөвшөөрөл олгосон прокурорын албан тушаал, нэр тодорхой байх;

3.2.7.шаардлагатай бусад мэдээлэл.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ

4.1.Мэдээлэх үүрэгтэй этгээд эрх бүхий хууль сахиулах байгууллагад мэдээлэл өгөхдөө нууцлал, аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр зөвхөн хүсэлтэд дурдагдсан энэ журмын 3.2.5-д заасан мэдээллийн хэлбэр, мэдээллийг хүлээн авах хэлбэр, горимоор мэдээллийг өгнө.

4.2.Эрх бүхий хууль сахиулах байгууллагын хүсэлт энэ журмын 3 дугаар бүлэгт заасан шаардлага хангаагүй бол мэдээлэх үүрэгтэй этгээд мэдээлэл өгөхөөс татгалзана.

4.3.Мэдээлэх үүрэгтэй этгээдээс эрх бүхий хууль сахиулах байгууллагад гүйлгээний тухай мэдээлэл өгөх бол “Банкнаас дансны хуулга авах загвар” эсхүл “Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдээс гүйлгээний тухай мэдээлэл авах загвар”-ын дагуу мэдээллийг бэлтгэж хүргүүлнэ.

4.4.Мэдээлэх үүрэгтэй этгээд хүсэлт хүлээн авснаас хойш энгийн горимоор бол ажлын 7 өдөр, яаралтай горимоор бол ажлын 3 өдөрт багтаан хариу өгнө.

ТАВ. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

5.1.Эрх бүхий хууль сахиулах байгууллага, мэдээлэх үүрэгтэй этгээд нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2.Энэ журамд заасан мэдээллийг хүлээн авах, хүлээлгэн өгөх, дамжуулах, шилжүүлэх, танилцах эрх бүхий этгээд нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангана.

5.3.Энэхүү журамд заасан мэдээллийг хуульд заасан нууцын зэрэглэл болон бусад тэмдэглэгээг тавьж бэхжүүлэх замаар нууцлах бөгөөд тэмдэглэгээг хийхдээ цаасан болон цахим баримт бичгийн бүх хуудасны баруун дээд буланд хийнэ.

5.4.Эрх бүхий хууль сахиулах байгууллага болон мэдээлэх үүрэгтэй этгээд нь хуульд заасан шаардлагад нийцүүлэн баталсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмыг үйл ажиллагаандаа мөрдөнө.

5.5.Эрх бүхий хууль сахиулах байгууллага болон мэдээлэх үүрэгтэй этгээд нь хуульд заасны дагуу кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудитыг эрх бүхий этгээдээр хийлгэж, гарсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

5.6.Энэхүү журамд заасан мэдээллийг хүлээн авах, хүлээлгэн өгөх, дамжуулах, шилжүүлэх, танилцах эрх бүхий этгээд мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголттой байна.

5.7.Энэхүү журамд заасан мэдээллийг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн, дамжуулсан, шилжүүлсэн, танилцсан этгээд хэн байхаас үл хамааран мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллаагүй бол тухайн ажилтнаас гадна байгууллага нь холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.

5.8.Эрх бүхий хууль сахиулах байгууллага болон мэдээлэх үүрэгтэй этгээдийн цахим шуудангаар илгээх мэдээлэл нь нууцлал бүхий холболттой байх бөгөөд зөвхөн цахим шуудангийн нууцлал, аюулгүй байдлын шаардлага хангагдсанаар мэдээллийг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүлээн авах эрх үүснэ.

5.9.Эрх бүхий хууль сахиулах байгууллага болон мэдээлэх үүрэгтэй этгээд энэ журамд заасан мэдээлэл, түүний нэмэлт тодруулгыг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүлээн авах албаны цахим шуудангийн хаягтай байх бөгөөд тус цахим шуудангийн хаягийн мэдээллийг жилд нэг удаа шинэчилж, энэ тухай мэдэгдэнэ.

5.10.Эрх бүхий хууль сахиулах байгууллага энэ журамд заасан цахим мэдээлэл, түүний нэмэлт тодруулга авах хүсэлт, мэдээлэх үүрэгтэй этгээд хүсэлтийн дагуу хүргүүлэх мэдээлэл, түүний нэмэлт тодруулгыг зөвхөн энэ журмын 5.9-д заасан албаны цахим шуудангийн хаягт илгээнэ.

5.11.Эрх бүхий хууль сахиулах байгууллага болон мэдээлэх үүрэгтэй этгээд нь энэ журмын 5.10-д заасны дагуу хүргүүлэх, хүлээн авах цахим мэдээлэлд нэвтрэх “Нууц үг”-ийг албан бичгээр улирал тутам солилцож, нууцлалыг хадгална.

5.12.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь цахим мэдээллийг илгээхдээ мэдээллийн бүрэн бүтэн байдал, нууцлал, аюулгүй байдлыг хангах, эрх бүхий албан тушаалтан мөн эсэхийг баталгаажуулах үүднээс мэдээлэл бүхий файлыг Цахим гарын үсгийн тухай хуулийн дагуу тоон гарын үсэг ашиглан баталгаажуулж илгээнэ.

5.13.Мэдээлэл хүлээн авах эрх бүхий хууль сахиулах байгууллагын эрх бүхий ажилтан нь зөвхөн албаны сүлжээнд холбогдсон компьютер тоног төхөөрөмжөөс мэдээлэлд хандана. Хувийн болон зөвшөөрөгдөөгүй төхөөрөмжид мэдээллийг хадгалах болон хуулбарлахыг хориглоно.

5.14.Эрх бүхий хууль сахиулах байгууллага нь мэдээллийг дараах байдлаар устгана:

5.14.1.цаасан мэдээллийг цаас устгагчаар;

5.14.2.цахим мэдээллийг зориулалтын файл устгагч программ хангамж ашиглан эргэн сэргэх боломжгүй байдлаар устгана.

ЗУРГАА. БУСАД

6.1.Энэхүү журмын хүрээнд мэдээлэх үүрэгтэй этгээдээс эрх бүхий хууль сахиулах байгууллагад мэдээлэл өгсөн нь Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 12.1, 12.2 дахь хэсэгт заасны дагуу нууц задруулсан гэж үзэхгүй бөгөөд хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

6.2.Хүсэлтэд хариу өгсөн мэдээлэх үүрэгтэй этгээд, түүний удирдлага, ажилтны талаар хүсэлтэд дурдагдсан тодорхой этгээд болон бусад гуравдагч этгээдэд мэдээлэхгүй.

6.3.Мэдээлэх үүрэгтэй этгээд, түүний удирдлага, ажилтан нь хууль сахиулах байгууллагаас мэдээлэл авахаар хүсэлт ирсэн, хүсэлтэд хариу хүргүүлсэн эсхүл хүргүүлсэн мэдээллийн талаар хүсэлтэд дурдагдсан тодорхой этгээд болон бусад гуравдагч этгээдэд мэдээлэхгүй.

6.4.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

_____оОо_____

БАНКНААС ДАНСНЫ ХУУЛГА АВАХ ЗАГВАР

Гүйлгээний мэдээлэл									Харьцсан дансны мэдээлэл			Гүйлгээ хийж буй хүний мэдээлэл		Гүйлгээний нэмэлт мэдээлэл	
Огноо	Гүйлгээ хийсэн цаг	Гүйлгээ хийсэн салбар	Теллер дугаар	Гүйлгээний код	Зарлага	Орлого	Үлдэгдэл	Гүйлгээний утга	Харьцсан данс	Харьцсан данс эзэмшигчийн нэр	Харьцсан банкны нэр	Гүйлгээ хийж буй хүний овог, нэр	Регистрийн дугаар	Журналын дугаар	Ханш
2020.03.02	10:00:00 PM	401	5455	1010		5000	5000	Кассаас	110100			Болд Бат	XX854254124	43332	1
2020.03.02	15:00:00 PM		50	1021	3000		2000	Тээврийн төлбөр	558545262	А ХХК	Хаанбанк	Интернэт банк		43332	2848
2020.03.03	16:00:00 PM	456	562	1020	2000		0	Зарлага				Болд Бат	XX854254123	22555	1
				Нийт	5000	5000	0	0		0	0	0	0		

БАНКНААС БУСАД МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС ГҮЙЛГЭЭНИЙ ТУХАЙ
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЗАГВАР

Д/д	Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдийн мэдээлэл			Үйлчлүүлэгчийн талаар мэдээлэл			Харилцагчийн авсан үйлчилгээний талаар мэдээлэл						Үйлчилгээний үзүүлсэн төлбөрийн талаар мэдээлэл			Шаардлагатай бусад
	хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар	үйлчилгээ үзүүлсэн ажилтны овог нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар	хуулийн этгээдийн хаяг	Хуулийн этгээд болон иргэний Овог, нэр, регистрийн дугаар	Ажил эрхлэлт	Хаяг, холбоо барих утасны дугаар	Үйлчилгээний Төрөл	Үйлчилгээ үзүүлсэн Огноо	Үйлчилгээний хамрах хугацаа	Үнэлгээ / мянган төгрөг/	онцлог шинж тэмдэг	Бусад мэдээлэл	Үйлчлүүлсэн огноо	Үйлчилгээний төлбөр, хураамж, ноён төлбөр /мянган төгрөг/	Төлбөр төлсөн этгээдийн нэр, банкны нэр, дансны дугаар	
1	даатгал						автомашинны даатгал	2021.09.30	2021.09.30-2021.12.31	65,000.00	2015 онд үйлдвэрлэгдсэн	өмнө даатгуулж байсан эсэх, ноён төлбөр авсан эсэх	2021.09.30	1,950.00	Бат овогтой Дорж бэлэн мөнгөөр тушаасан.	
2	үл хөдлөх хөрөнгө зуучлал						3 өрөө байр борлуулсан	2021.10.01	2021.10.01-2021.11.03	150,000.00	Гэрчилгээний дугаар	худалдах худалдан авах гэрээний дугаар	2021.10.01	3,000.00	Бат овогтой Доржийн Голomt банк 1111111111 тоот дансанд	
3	Үнэт металл, үнэт чулууны арилжаа						Алт борлуулсан	2021.12.20	2 сарын зугацаанд 2 кг	1,500,000.00	А компаниас худалдан авсан	орцын мэдээлэл гэх мэт	2021.12.20	1,500,000.00	Бат овогтой Доржийн Голomt банк 1111111111 тоот дансанд	
4	Үнэт цаасны салбар						Хувьцаа, бонд, бусад үнэт цаасны арилжаа	2021.12.15	арилжаа мийгдэх хугацаа	80,000.00	Нэр, тоо ширээг, нэгжийн үнэ		2021.12.20	800.00	Бат овогтой Доржийн Голomt банк 1111111111 тоот дансанд	
8	Виртаул хөрөнгө															
5	ББСБ						Зээл, хадгаламж	2021.11.01	2021.11.01-2022.01.01 2 сарын хугацаатай	30,000.00	зээл, хадгаламж	хадгаламж хамтран эзэмшигчийн мэдээлэл, барьцаа хөрөнгийн	2021.11.01	30,000.00	Бат овогтой Доржийн Голomt банк 1111111111 тоот дансанд	
6	Хадгаламж зээлийн хөршөө						Зээл, хадгаламж	2021.11.01	2021.11.01-2022.01.01 2 сарын хугацаатай	30,000.00	гишүүчлэлийн зээл, хадгаламж	бусад шаардлагатай мэдээлэл	2021.11.01	30,000.00	Бат овогтой Дорж бэлэн мөнгөөр тушаасан.	
7	Хөрөнгө оруулалтын сан						Хөрөнгө оруулсан	2021.10.15	2021.12.01-2023.12.01 3 жилийн хугацаатай	1,000,000.00						